

## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДАД ЭРХЗҮЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ НЬ

Э.Чулуунцэцэг

Нийгэм эдийн засгийн өөрчлөлтийг дагаж, хүмүүсийн амьдралын нөхцөл байдал, хэрэгцээ, сонирхол богино хугацаанд өөрчлөгдөж буй өнөөгийн нөхцөлд нийцүүлэн БСШУЯ-с ЕБС-д судлах түүх нийгэм, эрхзүйн боловсролын стандарт, зөвлөмжийг шинэчлэн /2003 онд/ мөрдөж байна.

Уг стандартын агуулга, аргазүй нь хувь хүний болон нийгмийн хэрэгцээнд тулгуурласан бага, дунд боловсролын түвшин агуулга, аргазүйн үндэс, орчин, нөхцөл, үнэлгээний шаардлагуудыг цогц байдлаар томъёолсон боловсролын баримт бичиг юм.

ЕБС-д шинэчлэгдсэн стандартыг хэрэгжүүлэхэд суралцагчид аливаа асуудлаар бие даан шийдвэр гарган ажиллах, амьдрах чадвартай, үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд зохицуулан шийдвэр гаргаж чаддаг болоход эрхзүйн боловсрол шийдвэрлэх үүрэгтэй болж байна.

Өнөөдөр боловсролын хүрээнд түүний дотор ЕБС-д хийгдэж байгаа өөрчлөлт шинэчлэлт нь боловсролын бүхий л талыг хамарсан цогц шинжтэй бөгөөд үүнийг гардан хэрэгжүүлэгч мэргэжлийн багш нарын үүрэг роль оролцоо, санаачлагад тулгуурлан, тэднээс мэргэжлийн үйл ажиллагааг үр ашигтай, чанартай болгох эрмэлзэл, бүтээлч үйл ажиллагаанд чиглэгдэж байгаа юм. ЕБС-ийн эрхзүйн хичээлүүдийн агуулга нь.:

- Дүрэм, журам, хууль
- Эрх ба үүрэг
- Төрийн байгуулал
- Салбар эрхзүй гэсэн 4 үндсэн айгаас

бүрдэж байгаа бөгөөд ай тус бүр нь хууль, эрхзүйн тодорхой мэдлэгийг агуулахын зэрэгцээ тухайн ангийн суралцагчдынхаа нас бие сэтгэхүйд нийцсэн эрхзүйн харилцааны чадвар дадлууд, хэрэглээг эзэмшүүлэхэд чиглэгдэх ёстой.

Иймээс мэргэжлийн багш нар эрхзүйн боловсролын агуулгын хүрээнд сургалтын хөтөлбөрөө боловсруулахдаа суралцагчдад шийдвэр гаргах бэрхшээлыг даван туулахад шаардагдах сурах ба сурах үйл ажилгааны агуулга мэдлэг бүтээх үйлийг төлөвлөхөөс гадна хэрэглээ болгох талд нь түлхүү анхаарч,

иргэн хүн эрх ашигаа хамгаалахаас гадна бусдын эрхийг хүндэтгэх, аливаа маргаантай асуудалыг хууль журамын дагуу шийдвэрлэх, буруутай үйлдэлдээ хариуцлага хүлээх хэрэгтэй шаардлагатай болгохыг тусгах нь үр дүнтэй болно. Багш сургалтын хөтөлбөрөө аль болох сурагчид юу хүсэж байгааг анзаарч, хэрэгцээ сонирхолд нь нийцүүлэн, олон хувилбартай практик чиглэлтэй, чөлөөт сэтгэлгээний чиг хандлагыг баримтална.

Судлагдахуун ба ур ухааны тогтолцоог уялдуулан, бидний ярьж заншсанаар идэвхтэй оролцооны аргууд аль ч ангид эрхзүйн хичээлийг явуулахад илүү тохиромжтойг бодолцож дунд ангиудад тохиолдол шинжлэх, ахлах ангиудад мэтгэлцээн, нотолгоо, баримт түших нь илүү үр дүнтэй болно.

Эрхзүйн хичээл нь бусад хичээлүүдээс илүү парактик амьдралд ойр байдгаараа онцлог бөгөөд дунд сургуульд хуулийн мэргэжилтэн бэлтгэдэггүйг анхаарч, нийгмийн харилцаанд өөрийгөө бэлтгэж, хууль, дүрэм журамд нийцүүлэн, биеэ авч явах дадал, итгэл үнэмшил төрүүлэх нь гол зорилго билээ.

Сургалтын үйл ажиллагааг 3 шатлалд хувааж болно.

- 1.Сургалтын өмнөх үе
- 2.Сургалтын үе
- 3.Сургалтын дараах үе гэж.

Эрхзүйн сургалтад дараах үеийн шатанд мэдлэгийг дадал төлөвшил хэрхэн бүрэлдэж буйг нь бататган чиглүүлэх зорилгоор хичээл заадаг багш, анги удирдсан багшийн тусламжтайгаар тодорхой сэдвээр бүтээлч даалгавар өгч, багаар болон ганцаарчлан гүйцэтгүүлж ангидаа болон бусад бүлгүүдэд тайлагнах, үзэсгэлэн гаргах, бүтээлээ хамгаалах зэргээр хамтарч ажиллавал үр өгөөжтэй болно.

Дэлхийн улс орнуудад “Иргэний боловсрол” хичээлийг сурагчдад нийгмийн олон талт харилцаанд идэвхтэй ашигтай оролцох эрх, эрх чөлөөг хүндэтгэх, шударга байх, аливаа эрсдлээс өөрийгөө хамгаалах чадвар суулгахад чиглүүлэн, сургалт явуулж дадал хандлагыг төлөвшүүлж иржээ.

Манай оронд “Хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулах” үндсэн хуулийн заалтаа

хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн гишүүдийг төлөвшүүлэн иргэншүүлэхэд эрх зүйн боловсрол төдийгүй иргэний боловсролыг системтэй бүх нийтийг хамарч олгох нь боловсролын байгууллагын хойшлуулашгүй эн тэргүүний зорилт болж байна.

БСШУЯ-аас 2005-2006 оны хичээлийн жилээс ЕБС-д “Иргэний боловсрол” хэмээх хичээлийг оруулахаар тусгасан байна. Гэвч мэргэжлийн арга зүйн сургалтанд оролцож буй (2008онд) дунд сургуулийн багш нарын ярианаас үзэхэд “Иргэний боловсрол” хичээл бараг ордоггүй одоо хүртэл нэг мөр болсон агуулга, хөтөлбөр байдаггүй, зөвхөн иргэншил хичээлүүдээр л эрх зүйн чиглэлийн агуулгаа баримталдаг болох нь ажиглагдаж байлаа.

Ардчилсан нийгмийг эрүүл байлгахад иргэдэд иргэний боловсрол олгох нь чухлыг НҮБ-ийн ЮНЕСКО-гоос Дэлхийн орнуудад хандсан сургалтын хөтөлбөрийг дараах чиглэлээр сургалтын агуулгадаа хэрэгжүүлэхийг зөвлөсөн байна Үүнд:

- Хувь хүн, нийгмийн хоорондох харилцаа
- Иргэн төрийн хоорондох харилцаа
- Иргэн ардчилсан ёсны хоорондох харилцаа
- Иргэний эрх үүргийн хоорондох харилцаа

Иймээс боловсролын асуудал эрхэлсэн мэргэжилтэнг иргэний боловсрол хөтөлбөртөө өөрчлөлт хийж өсвөр үеийнхнийг нийгмийн оролцоот иргэн болгоход нь эзэмшсэн мэдлэгийг практикт асуудлыг шийдвэрлэхэд хэрэглэх хэрэглээ болгоход мэргэжлээрээ багаараа хамтран ажиллах таатай нөхцөл байна. Сурагчид сургуульд суралцах гэж ирдгийн адил багш бидний хувьд сургууль тасралтгүй суралцах орчин - орон зай билээ.

Багшлах ухаан гэдэг нь өөрөө тасралтгүй суралцахын дээд хэлбэр. Эрхзүйн ба иргэний боловсролын чанар, үр өгөөжийг дээшлүүлж, идэвхтэй оролцоот, зөв иргэнийг төрүүлэхэд багш нар маань судлагдахуун төвтэй хөтөлбөрийг, хэрэглээ төвтэй хөтөлбөрт шилжүүлж хэрэглээ болсон өсвөр үеийнхний мэдлэг нь нийгмийн харилцааг эерүүлнэ хэмээн найдаж байна.

